

Монгол Улс
НЭЗХДШ-ТС-ийн баримт бичигт
иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс санал авах уулзалт
2017 оны 10-р сарын 3

Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл ibaatarkhuu@worldbank.org и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.

Дэлхийн Банк Групп нь (ДБГ) Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар үзэл бодол, саналаа солилцох зорилгоор 2017 оны 10 дугаар сарын 3-нд иргэний нийгмийн байгууллагын (ИНБ) 53 төлөөлөлтэй уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

1. Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
2. Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
3. Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДББ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Дэлхийн Банк Группын танилцуулах илтгэлийн дараа, оролцогчид зөвлөлдөх уулзалтын үйл явцын талаар санал гаргасныг тус тэмдэглэлийн “ДБГ-ын зөвлөлдөх уулзалтын талаарх санал” хэсэгт тэмдэглэв. Улмаар оролцогчид төлөөлж буй байгууллагынхаа үйл ажиллагааны чиглэлийн дагуу 6 бүлэгт хуваагдав. Зургаан (6) дэд бүлгийн хэлэлцүүлгийн чиглэлийн дагуу оролцогчдын санал хүсэлтийг дор ангилан тэмдэглэв.

Ангилал	Оролцогчдын санал
<p style="text-align: center;">Дүн шинжилгээний баримт бичигт тусгах санал (боломж, сорилт, тулгамдсан асуудал ба ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга замууд)</p>	<p><u>Ядуурал ба Хөгжил</u></p> <ul style="list-style-type: none"> • Ядуурлын судалгааны үзүүлэлт бодит байдлаас ялгаатай мөн хоорондоо нийцдэггүй. Эдийн засгийн өсөлт сулраад байхад ядуурлын түвшин яагаад буураад байгаа шалтгааныг тайлбарлах хэрэгтэй. Ядуурлын судалгааны аргачлал, “ядуурал” гэдгийн тодорхойлолтыг илүү сайн ойлгох хэрэгтэй байна. Дэлхийн хэмжээнд, бүс нутаг, улс орон, тухайн улсын муж бүс дотроо ядуурал гэж юу болох талаар нийтлэг ойлголт, тодорхойлолтыг бий болгох шаардлагатай. • Нийгмийн халамж хамгийн их хэрэгцээтэй байгаа зорилтот бүлэгт чиглээгүй. • Төрийн албаны тогтворгүй байдал, албан хаагчдын чадавхи сул байгаа нь хөгжлийн садаа болж, ядуурлыг бий болгож байна. • Хөгжил гэдэг нь ямар салбар (боловсрол, эрүүл мэнд гэх мэт) хамгийн их баялгийг буй болгодог гэдгээр бус хэдэн хүмүүст эергээр нөлөөлсөн гэдгээр тодорхойлогдох хэрэгтэй. Үүнийг цаашид тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх салбаруудаа сонгохдоо анхаарах хэрэгтэй. Жишээ нь, уул уурхайн салбар төсвийн орлогын дийлэнх хувийг бүрдүүлдэг боловч ажиллах хүчний 4-7% хувь нь л уул уурхайн салбарт ажилладаг. Ажиллах хүчний дийлэнх хувь нь цалин хөлс багатай нийгэм, боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллаж байна. • Банкны салбар хэт хатуу шаардлагатай, зээлийн хүү өндөр, санхүүгийн хүртээмж хязгаарлагдмал байна. Санхүүжилтийн эрэлт хэрэгцээ өндөр байдаг ч зээлийн хүү өндөр байна. Иймд ихэнх хувь хүн, байгууллагууд зээлээ төлөхийн тулд мөнгөө зарцуулж, банкны салбарыг дэмжээд өөрсдөө ядууралд орж байна. • Концессийн гэрээнүүд (ТХХТ) нь засгийн газар/УИХ-ын эрх мэдэлтэй хүмүүс өөрсдийн бизнесийг дэмжих боломжийг олгож, шударга бус өрсөлдөөнийг

цэцэглүүлсэн. Ялангуяа боловсрол, эрүүл мэндийн салбарт концессийн гэрээ ашиглаж байгаа нь улс орны хөгжилд саад болж байна.

- Дэлхийн Банкны жендэрийн үр нөлөөний үнэлгээг сайн туршлага болгон нэвтрүүлж Хууль тогтоомжийн тухай хуулинд тусгах хэрэгтэй. Ингэснээр цаашид шинээр боловсруулж батлах бүх хуулиудад жендэрийн асуудлыг харгалзан тусгах боломж бүрдэнэ.
- Ашигт малтмалд суурилсан хөгжил, загварын оронд мэдлэгт суурилсан төлөвлөлт, хөгжлийг дэмжих ёстой; иймд ИНБ-ууд гэх мэт нийгмийн хамгийн идэвхтэй оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай.
- Татварын бодлогын зохистой байдлыг үнэлэх хэрэгтэй. Татварын шатлалтай системийг ашиглах нь зүйтэй. Ялангуяа аж ахуйн нэгжийн албан татвар болон гаалийн татвартай холбоотой тэгш байдлыг хангасан бодлого хэрэгжүүлснээр баян, ядуугийн ялгааг бууруулах ёстой. Сүүлийн 20 жилийн хугацаанд хувийн хэвшлийг дэмжих, ялангуяа татварын хөнгөлөлт үзүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийн төслүүд болон уул уурхайн тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөх гэх мэт хувийн хэвшлийг дэмжихэд чиглэсэн бодлого баримталж ирсэн. Гэвч одоо тулгамдаж буй улсын төсвийн хүндрэл, нийгмийн суурь үйлчилгээг хангахад чиглэсэн санхүүжилт хязгаарлагдмал байгаа зэргийг харгалзан татварын бодлогыг өөрчлөх шаардлагатай байна. Бизнес эрхлэгчдэд үзүүлдэг татварын өршөөлийг зогсоох ёстой.

Хүний эрх ба Жендэр

- Холбогдох олон хууль батлагдсан боловч мэдээлэл түгээх, холбогдох чадавхийг бэхжүүлэх, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг зохистой төлөвлөх үйл явц хангалтгүй байгаагаас хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Мэдээллээр хангагдах хувь хүний эрх зөрчигдөж байна.
- ДБ-аас санхүүжүүлсэн төслүүдийг халамж гэж хардаг. ДБ-аас санхүүжүүлсэн төслүүдэд оролцох, үр өгөөж хүртэх боломж хязгаарлагдмал байдаг. ДБ-ны дэмжлэгтэй төслүүд нь дэмжлэг туслалцаа хэрэгтэй байгаа хүмүүстээ хүрдэггүй, харин танил талтай хүмүүст хүртдэг.
- ДБ-ны дэмжлэгтэй төслүүдийн хөндлөнгийн хяналт хангалтгүй. ДБ-ны Суурин төлөөлөгчийн газрын ажилтнууд үр дүнд гаргах, зорилтот үр өгөөж хүртэгчдэд тусалж ажиллах сэтгэл дутдаг.
- Ялгаварлан гадуурхалтын тухай хууль, Хүний эрхийн төлөө тэмцэгчдийн эрхийг хамгаалах тухай хууль; Олон нийтийн сайн сайхны тухай хууль зэрэг хэд хэдэн хуулийг баталснаар хүний эрхийн эрх зүйн орчинг цаашид хөгжүүлэх шаардлагатай.
- Боловсролын бодлого нь хүний эрхийн талаар зааж сургахыг дэмждэг ч иргэний үүрэг хариуцлагыг заах тухайд орхигдуулсан байдаг. Жендэр ба бэлгийн боловсролын агуулгыг сургалтын хөтөлбөрөөс хассан нь амжилтаасаа ухарсан алхам болсон. Улсын хэмжээнд иргэний болон соёлын цогц боловсрол олгох явдал дутмаг. Ажиллах хүчин, төрийн албыг хөгжүүлэх, татан оролцуулах системтэй арга барил хэрэгтэй байна. Бидэнд хариуцлагатай, сэтгэлтэй иргэн, аж ахуйн нэгж, ИНБ-ууд дутагдаж байна. Боловсрол нь улс орны хөгжлийн стратегийн салбар байх ёстой. Сургуулиуд хүүхдүүдэд бага наснаас нь эхлэн хүүхдийн хүний эрхийн асуудлыг зааж сургах ёстой.
- Төрийн үйлчилгээг хүргэх, зохицуулах, зөв зохистой удирдах явдал хангалтгүй байна. Жишээ нь 5 хүртэл тооны цэцэрлэгтэй хороонд шинэ цэцэрлэг барих зөвшөөрлийг төр олгосон байхад зарим хороо огт цэцэрлэггүй байна.
- НҮБ-ийн Ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт дэвшүүлсэн санал хэрэгжихгүй байна.
- Одоогоор бидэнд тулгарч буй бүх асуудлууд засаглалын хямралаас үүдэлтэй.
- Хөгжлийн бодлого нь нотолгоонд суурилсан байх ёстой.
- Бид олборлох салбарт суурилсан эдийн засгаас мэдлэгт суурилсан тогтвортой хөгжлийн загварт шилжих хэрэгтэй. Энэ нь ирэх 5 жилд ДБ-ны үйл ажиллагааны уриа байж болох юм.
- ДБ нь аливаа улс орны болон ард иргэдийн хөгжлийн төлөө үйл ажиллагаагаа явуулдаг учраас ДБ өөрийн бүхий л үйл ажиллагаандаа, стратеги болон төслийн үйл ажиллагаандаа хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ хийж байх ёстой.

- Жендэрийн Үндэсний Хороо яамны харъяа үйл ажиллагаа явуулж байгаа нь жендэрийн бодлого, хөтөлбөрийн ач холбогдлыг сулруулж байна. Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулах орон тооны ажилтнуудын чадавх, нөөц бололцоо дутмаг байгаа нь ялгаварлан гадуурхах гэх мэт асуудлыг улам нэмэгдүүлж байна. Жендэрийн Үндэсний Хороо нь өмнөх шигээ Шадар сайдын удирдлага дор ажиллах ёстой. Жендэр болон хүний эрхийн асуудлын ач холбогдлын талаар төрийн байгууллагууд өргөн хүрээний ойлголтгүй. Найробигийн зөвлөмжүүд энэ талаар зөрчигдөж байна.
- Эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн оролцоо бага. Жишээ нь, хөрөнгө өмчлөлийн хувьд. Эмэгтэйчүүдийн эзэмшлийн хөрөнгө болон албан бус хөдөлмөрөөр дамжуулан эмэгтэйчүүдийн эдийн засагт оруулах хувь нэмрийн талаар холбогдох статистик мэдээ байдаггүй. Эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог төрийн бодлого зохих түвшинд харгалзаж үздэггүй. Эмэгтэйчүүд олон хүүхэд дараалан төрүүлсний дараа ядууралд өртөх хандлагатай байдаг. Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахын тулд эмэгтэйчүүдийн нийгэм-эдийн засгийн ядуурал, эмзэг байдлыг шийдвэрлэх нь чухал юм.
- Дэлхийн Банк Үндэсний Статистикийн Хороотой хамтран ажиллаж байгаа боловч ҮСХ-нд хүйсээр ялгасан судалгаа, статистик гаргах чадавх хараахан алга байна. Статистик мэдээллийг бодлого боловсруулахад ашиглах явдал хязгаарлагдмал байна.
- Улсын хэмжээнд тэгш бус байдал их байна. Нийслэлийн зарим хороод хэт олон цэцэрлэг (5-аас дээш) байхад хотын захын хорооллын зарим хороонд ийм байгууламж дутагдаж байна.
- Монголын ард түмэн дотоод, гадаадын хөдөлмөрийн зах зээл дээр харьцангуй давуу талаа алдсан, үүнийг сэргээн сайжруулах шаардлагатай. Техник, мэргэжлийн боловсролын сургалт нь ядуурлыг устгах үндэс суурь болох учраас цаашид хөгжүүлэх нь зүйтэй.

Байгаль орчин

- Сүүлийн 25 жилийн хугацаанд ДБ-ны Монгол улс дахь үйл ажиллагааны байгаль орчны нөлөөллийн шинжилгээг ДБ хийх ёстой. Үүнийг ИНБ-уудтай хамтран хийж болно. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг мал аж ахуй, уул уурхайн салбар гэх мэт салбар тус бүрээр хийх нь зүйтэй.
- ДБ нь төслийн үр дүнд хангалттай анхаардаггүй. Үр дүнгийн үнэлгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг 5 жил тутам хийх нь зүйтэй.
- ДБ-ны хамгааллын стандартыг Монгол улсад нэвтрүүлж, холбогдох бодлогод дүн шинжилгээ хийх хэрэгтэй.
- Дэлхийн Банк Засгийн газартай хамтран ажиллаж, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. Төрд хариуцлагын механизм дутагдаж байна.
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдээгүй Дэлхийн Банкны дэмжлэгтэй төслүүдийн үр дагаварт хэн хариуцлага хүлээх вэ? ДБГ-ын ашгийн хэдэн хувь нь байгаль орчны төслүүдэд зарцуулагддаг вэ?
- Уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө байгаль орчин, нийгэм, эдийн засаг, улс төрийн нөлөөллийн үнэлгээ хийх ёстой.
- Усны асуудлыг яагаад ДБ-ны санхүүжилттэй уул уурхайн дэд бүтцийг дэмжиж буй төслийн доор хамааруулан харгалзан үзэж байна вэ?
- Дэлхийн бусад аль ч оронд ашиглахыг хориглосон, уул уурхайн салбарын аюултай технологи, үйл ажиллагааны талаар ДБ яагаад бодлогын зөвлөгөө өгөхгүй байна вэ? Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн уул уурхайн стандарт, нөхцлүүдийг ДБ нэвтрүүлэх талаар ажиллах ёстой.
- Оюу Толгойн гэрээнд ДБ зөвлөсөн, тухайн үедээ уул уурхайн салбарын жишиг хамгийн сайн гэрээ боллоо гэж үзэж байсан. Гэвч бодит байдалд энэ үлгэр жишээ болсон гэрээ нь олон асуудлыг үүсгэсэн, алдаагаа засч залруулах оролдлого хийх бүрт төр солигддог. ДБ нь гэрээний үр дүнг дахин үнэлж, бодлогын зөвлөгөөний талаарх мэдээллийг нээлттэй болгох хэрэгтэй. ОТ-н гэрээ нь Монгол улсад хангалттай үр өгөөж авчирсангүй, энэ төслийн үр өгөөжийг зөв ашиглаж чадсангүй.
- НЭЗХДШ нь нийгэм, эдийн засгийн асуудлаас гадна байгаль орчин, уур амьсгалын асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэй.

- Нөхцөлт зээлийн нөхцлүүдийг олон нийтэд ил тод болгох ёстой.
- Монгол Улсын Засгийн газрын нийт өрийн хэдэн хувийг ДБ-ны зээл эзэлдэг вэ? ДБ баталгаа гаргадаг. ДБ өрийг мөн салбар салбараар нь нарийвчлан тооцоолж гаргах хэрэгтэй.
- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ уугуул иргэдийн асуудлыг харгалзан үзэх хэрэгтэй.
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт нь орон нутгийн ард иргэдийн амьдрах хэв маягт нөлөөлж байгаа нь илэрхий байгаа боловч иргэдийн эрүүл мэндэд байгаль орчны үзүүлэх нөлөөг үл тоомсорлож байна. Болзошгүй эрсдэлийг бууруулах ямар арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бэ? ДБ байгаль орчны нөхцөл байдал, өөрчлөлтөөс шалтгаалсан өвчлөл гэх зэргийг оролцуулан асуудалд дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын эрүүл мэндийг онцгойлон анхаарах хэрэгтэй. Уул уурхайн салбарын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг НЭЗХДШ-ний хүрээнд авч үзэх шаардлагатай.
- Дэлхийн Банк уул уурхайн салбарт түшиглэсэн эдийн засгийн хөгжлийг дэмжсэн. НЭЗХДШ нь уул уурхай бусад салбаруудад ямар нөлөөлөл үзүүлсэн, хэр их хэмжээний дарамтыг бусад салбаруудад үзүүлсэн талаар судалж тусгах хэрэгтэй. Жишээ нь, хүн болон малын эрүүл мэндэд уул уурхайн салбарын үзүүлсэн нөлөөллийг оношилж, мөнгөн дүн буюу тоон үзүүлэлтээр үнэлэх хэрэгтэй. Бусад салбарт үзүүлсэн сөрөг нөлөөллийг тооцож хассаны дараа уул уурхайн хөгжлийн цэвэр үр өгөөжийг тооцоолох ёстой.
- Уул уурхайн салбар руу чиглэсэн оюуны шүүрэл нь бусад салбарын хөгжилд саад болж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал

- Холбогдох хуулийн хэрэгжилтийг хангахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэх төрийн байгууллага байдаггүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан тусгай агентлаг байгуулж болох боловч санхүүжилтийн асуудал байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хариуцсан байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл байх ёстой.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хууль эрх зүйн орчин сайн хөгжөөгүй. Өнөөгийн хууль тогтоомжууд нь тунхаглалын чанартай баримт бичиг төдий, хэрэгжилтийг хангах зохицуулалтгүй байна. Хууль батлагдсаны дараа тухайн хуулийг хэрэгжүүлэхээр гаргадаг тогтоол, шийдвэр, журам, зааврууд нь тодорхойгүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байдаг нь Монгол Улсын хуулиудын нийтлэг асуудал болсон. Холбогдох чадавхийг бэхжүүлэх, эрх бүхий байгууллагын доод түвшний удирдах ажилтнууд хуулийг гуйвуулах, буруу тайлбарлахыг зөвшөөрөхгүй байх замаар хуулийн хэрэгжилтийг сайжруулах хэрэгтэй.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсруулсан бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд гаргах боломжуудыг эрэлхийлж болно.
- Төрөөс гадаадад ажиллаж буй хүмүүсийн тоог бууруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлснээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө жил бүр буурч байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг ДБ байгуулж болно.
- Малжуулах хөтөлбөрийн оронд малчинжуулах буюу малчдыг дэмжих хөтөлбөрийг боловсруулах хэрэгтэй. Энэ нь Улаанбаатар хотын хэт төвлөрөл болон ядуурлын асуудлыг шийдвэрлэхэд туслах юм. Учир нь хөдөө орон нутгаас хот суурин газар руу шилжих хөдөлгөөн ядуурлын гол шалтгаан болдог. Малчид зуданд малаа алдахад малжуулах хөтөлбөр, гэр бүлийн гишүүдээс туслалцаа дэмжлэг авах гэх мэтээр дахин малтай болох олон боломж бий. Гэвч эдгээр хүмүүсийг хөдөө орон нутагтаа очиж, нутгийн иргэддээ тустай дэмтэй, нэр төртэй амьдрахыг дэмжсэн тусгай хөтөлбөрүүд хэрэгтэй байна.
- ДБ ядуурлыг устгахын төлөө ажилладаг. Иймд ДБ өнгөрсөн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хэрхэн дэмжиж ажилласан, хөгжлийн бэрхшээл ядууралд хэрхэн нөлөөлж байгаа талаар дүн шинжилгээ хийх хэрэгтэй.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын хүртээмж хязгаарлагдмал байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг жирийн сургуульд сурах боломжийг нээсэн

стратеги, төлөвлөгөөг сургууль бүр боловсруулж хэрэгжүүлэх ёстой. Бүс нутгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийг хөгжүүлэх ёстой.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандах нийгмийн хандлагыг өөрчлөх ёстой. Хүүхдүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй хамт суралцах талаар нээлттэй сэтгэлгээтэй байх ёстой.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургаж чадах багш нарыг бэлтгэх сургалт чухал.
- Бакалавраас дээш түвшний боловсрол эзэмших боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хэрэгтэй. Эцэг эхчүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сайн боловсрол эзэмшүүлэхийн тулд чадах бүхнээ хийхийг хичээдэг боловч хүүхдүүд нь ихэвчлэн сургалтын төлбөрөө төлж чадахгүйн улмаас дээд боловсрол эзэмшиж чаддаггүй.
- Шийдвэр гаргах түвшинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, тэдний санал бодол, дуу хоолой үгүйлэгдэж байна. Цөөнхийн санал бодлыг сонсдоггүй. Энэ талаар ДБ дэмжлэг үзүүлэх ёстой.
- Төрийн зарим чиг үүргийг ИНБ-ууд гүйцэтгэх боломжтой боловч төрөөс ийм зохицуулалт хийхийг хүсдэггүй.
- Өнөөгийн нийгмийн халамж оновчтой бус. Зорилтот бүлэгт илүү чиглэсэн, зөв зохистой нийгмийн халамжийн үйлчилгээг бий болгох хэрэгтэй. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн үр ашгийг гол төлөв хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүртдэг гэсэн нийтлэг ойлголт байдаг. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн халамжийн багахан хэсгийг л хүртдэг.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн зах зээлийг бий болгох боломжуудыг дэмжих хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хөдөлмөр эрхэлж, улс орныхоо эдийн засагт хувь нэмэр оруулахыг хүсдэг, жижиг бизнес эрхэлдэг боловч зах зээлд нэвтрэх боломж нь хязгаарлагдмал. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Европын зах зээлд борлуулахад нь ДБ туслах боломжтой.
- Нийгмийн асуудлыг шийдэхэд чиглэсэн нийгэмд чиглэсэн зээл, зээлийн үйлчилгээг нэвтрүүлэхэд ДБ дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Банкны салбарын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн ядуурлыг бууруулах хөтөлбөрүүд хэрхэн хэрэгжсэн, холбогдох санхүүжилтыг хэрхэн ашигласан талаар НЭЗХДШ-д тусгах нь зүйтэй.
- Уул уурхайн сөрөг нөлөөлөл болон байгаль орчны асуудлын улмаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо нэмэгдэж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд оролцох явдал хязгаарлагдмал хэвээр байна. Төрийн бүх шатны байгууллага үр дүнгийн гэрээ байгуулж ажиллахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрч ажилласан байдлыг ажлын гүйцэтгэлийн нэг шалгуур болгож ашиглах нь зүйтэй.
- Нийгмийн халамж хэт хавтгайрсан, нэг хүнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний тоо хязгаарлагдмал байдаг талаар шүүмжлэл бий. Хараагүй иргэдэд үзүүлж буй цөөн тооны халамжийн үйлчилгээ хангалтгүй учраас цогц дэмжлэг хэрэгтэй.
- Хүнсний аюулгүй байдал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог нэмэгдүүлж байна. Гарал үүсэл, чанар нь тодорхойгүй малын вакцин малын эрүүл мэндийн олон асуудлын шалтгаан болдог төдийгүй улмаар хүнсний бүтээгдэхүүний чанарыг доройтуулж байна.

Боловсрол

- Боловсрол дээр чанар, хүний хөгжлийн асуудлыг орхигдуулан, сургуулиудыг өнөөдөр зөвхөн байшин барилга, биет байгууламж гэж ойлгогдоход хүрчээ.
- Монголчууд боловсролын үнэ цэнийг өндрөөр үнэлдэг учраас боловсролын салбарыг хөгжүүлэх боломж Монгол улсад их бий. Монголчууд боловсролын өлсгөлөнд байна - иргэд зээл авч, хүүхдийнхээ сургалтын зардлыг төлөхөд бэлэн байна.
- Боловсролын тэгш бус бодлого боловсролын тогтолцоог гажуудуулж байна. Боловсролын салбарын бодлого, санхүүжилт, засаглал нь цаашид шийдвэрлэвэл зохих гол асуудлууд мөн.

- Өнөөгийн боловсролын бодлого элит боловсролыг дэмжсэн. Сургалтын өндөр төлбөртэй боловсролын үйлчилгээ нь тэгш бус байдал, харилцан адилгүй тэгш бус боловсролыг бий болгож байна.
- Засаглалын хямрал, ялангуяа төрийн албаны нөхцөл байдал сургууль, цэцэрлэгт ч нөлөөлж, улс төрийн нөлөөгөөр сургууль цэцэрлэгийн захирал, ажилтнууд ч өөрчлөгдөж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өөр хэлтэй бусад бүлгүүдийг зохих ёсоор харгалзсан бүх нийтийн оролцоог хангасан боловсролын бодлогыг дэмжих шаардлагатай. Энэ асуудлыг шийдвэрлэх чадавхитай боловсон хүчин, хүний нөөц Боловсролын Яаманд дутагдаж байна.
- Тэгш байдлыг хангасан, үр дүнд чиглэсэн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй.
- Монгол улс дахь сургуулийн өмнөх боловсролын талаар явуулсан ДБ-ны сүүлийн үеийн судалгаанд боловсролын салбар дахь төсвийн санхүүжилтийн үр өгөөжийг нийгмийн харьцангуй боломжтой айл өрхүүд илүү хүртэж байна гэж тэмдэглэсэн байдаг. ДБ боловсролын салбарт хувийн хэвшлийг дэмжих ёсгүй, жишээ нь хувийн хэвшлийн цэцэрлэг, сургуулиудад дэмжлэг үзүүлэх гэх мэт.
- Монгол улс хүчтэй, төрийн санхүүжилттэй боловсролын тогтолцоотой байсан. Дэлхийн Банк бодлогын дэмжлэг үзүүлэх замаар энэ уламжлалт тогтолцоог сулруулахгүй байх ёстой. Тэгш хамруулан сургалт, боловсролын мөн чанар, агуулгыг ойлгодог боловсон хүчнийг Боловсролын яаманд бий болгох талаар ДБ туслах хэрэгтэй. Жишээ нь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан боловсрол, олон улсын тэргүүн туршлагыг Монгол улсын онцлогт тохируулан нэвтрүүлэх мэдлэг чадвартай байх гэх мэт.
- 6 настай хүүхэд сургуульд орж эхлэх нь Монгол хүүхдүүдийн хувьд тохиромжтой юу? Зургаан настай хүүхдүүд, ялангуяа хөдөө орон нутагт сургуулийн өмнөх чанартай боловсрол эзэмшиж чадаагүй байдаг учраас сургуулийн орчинд бэрхшээлтэй тулгардаг. ИНБ-ууд энэ асуудлыг авч үзэх хэрэгтэй. Хүүхдээ харж хандахын тулд аймаг, сумын төвд ээжүүд амьдарч байгаа нь гэр бүл салангид амьдрах, салахад хүргэж байна.
- Боловсролын салбарын ёс суртахуун, ёс зүйн асуудал эргэлзээтэй байна - бүх сургуулиуд ашгийн бус гэж бүртгэгддэг, тооцогддог. Монгол улсад бүртгэлтэй 25,000 орчим ТББ байдгаас ихэнх нь ашгийн төлөө сургууль, хэвлэл мэдээллийн байгууллагууд байдаг. Гэвч өндөр төлбөртэй хувийн сургуулиуд өнөөдөр улсын төсвөөс урсгал зардлын санхүүжилт авсаар байна. НЭЗХДШ-д энэ талаар судалж тусгах хэрэгтэй.

Засаглал

Сорилтууд:

- Дараах үндсэн шалтгааны улмаас засаглалын хямрал үүсч байна: эдийн засгийн өрөөсгөл бүтэц (ДНБ-д үйлдвэрлэлийн салбар бус уул уурхай, банкны салбар давамгайлсан; хөдөлмөрийн бүтээмж салбар хоорондын уялдаа холбоо, харилцаа байхгүй); эрх мэдэл, орлого, хөрөнгийн тэгш бус хуваарилалт (энэ нь эрх мэдлийн тэгш бус хуваарилалтаас үүдсэн); ба төлөөллийн хямрал (УИХ-д нийгмийн янз бүрийн бүлгүүдийн төлөөлөлтэй байх тэгш байдал хангагдаагүй). Эдгээр гурван үндсэн шалтгаан нь хоорондоо харилцан уялдаатай бөгөөд бүх асуудлын мөчлөгийг бий болгож байна. Сайн засаглалын талаарх арга хэмжээ нь засаглалын зөв түвшинд эсвэл зөв асуулт/асуудалд чиглээгүй байж болох талтай.
- Сайн засаглалыг хөгжүүлэхийн тулд ихээхэн анхаарч дэмждэг. Гэвч энэ сайн засаглал нь эдийн засгийн хөгжилд хүрэхийн өмнөх алхам биш гэдгийг бусад орны жишээ, нотолгоо харуулж байна. Эдийн засгийн сайн суурь, бүтцийг бий болгох эсвэл тодорхой салбарт ДБ нөөцөө зарцуулж чадаж байгаа эсэх нь бидний хувьд асуулт хэвээр байна.
- Бүтээмжтэй салбарт хөрөнгө оруулах нь хөгжлийг хангах олон талын үр нөлөөтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боломж олгосноор тэдний орлогыг нэмэгдүүлж улмаар сайн засаглалыг дэмжихэд түлхэц болох бодлогод нөлөөлөх эрх мэдлийг нь нэмэгдүүлэхэд туслах юм.

	<ul style="list-style-type: none"> • Төрийн бүх шатанд хариуцлагын тогтолцоо сул байгаагаас Монгол улсад засаглалын хямрал нүүрлэсэн. • Төрийн албанд хариуцлагын чадварыг нэмэгдүүлж, чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байна. • Улс орны эдийн засгийг хөгжүүлэх өнөөгийн загварыг НЭЗХДШ-нд үнэлж дүгнэх хэрэгтэй. Одоогийн эдийн засгийн хөгжлийн загварыг оношилж дүгнэсний дараа цаашдын хөгжлийн загварыг тодорхойлох хэрэгтэй.
<p>ДББ-ийн зөвлөлдөх уулзалтын талаарх санал</p>	<ul style="list-style-type: none"> • Зөвлөлдөх уулзалтыг НЭЗХДШ болон ТС-т санал авах зорилгоор зохион байгуулж байгаа гэж ойлгож байна. ДБ-ны дотоод бодлого, журмын дагуу энэ хоёр баримт бичгийг салангид үйл явцаар тусад нь боловсруулах ёстой байдаг. НЭЗХДШ-г ДБ-ны шинжээчид хийж, дүн шинжилгээ оношилгоон дээр тулгуурлаж ТС-ийн төслийг боловсруулдаг. Улмаар ТС-ийн төслийг оролцогч талуудаар хэлэлцүүлж санал авдаг. Дэлхийн Банк 25 жилийн хугацаанд Монгол улстай хамтран ажилласан, 25 жил бол урт хугацаа. Хэрэв 25 жилийн хамтын ажиллагаандаа оношилгоо, дүн шинжилгээ хийхгүй юм гэхэд сүүлийн 4 жилийн хугацааны хамтын ажиллагаандаа оношилгоо, дүн шинжилгээ хийх ёстой. Хүчин чармайлт гаргаагүй, цаг хугацаа, нөөц бололцоо дутмаг гэх мэт олон шалтгааны улмаас Монгол улс өөрөө сайн оношилгоо хийж чадаагүй л байна. Иймд Дэлхийн Банкны мэргэжилтнүүд, шинжээчид энэхүү оношилгоо, дүн шинжилгээний ажилд туслалцаа үзүүлсний дараа ТС-ийг оролцогч талуудтай зөвлөлдөх хэрэгтэй. Бодит байдал хөндлөнгөөс хэрхэн харагдаж байгааг ДБ бидэнд харуулах ёстой. Энэ хөндлөнгийн үнэлгээ бидэнд хэрэгтэй байна. • ДБ зорилгоо хос зорилго гэж өөрчилсөн боловч ядуурлаас ангид дэлхий гэдэг агуулга хэвээр хадгалагдсан байдаг. 2012 оноос өмнө ядуурлын түвшин 39% байсан. ДБ-ны аргачлал шинэчлэгдсэн тул 2012 оны 7-р сард ядуурлын түвшин 29%, дараа нь 27% гэж мэдэгдсэн. Дараа нь 21% болж буурсан. Оношилгоо, дүн шинжилгээнд ядуурлын нөхцөл байдал яг ямар байгаа, ядуурлын түвшин яагаад эрс өөрчлөгдөөд байгаа талаар тодорхой тусгахыг бид хүсч байна. Эдийн засгийн өсөлт буурсан үед ядуурлын түвшин буурч байгаа мэт харагдаад байгаа учраас ядуурлын түвшиний ойлгомжгүй байдлаас болж егөөдөлтэй дүр зураг харагдаж байна. Эдийн засаг буурч сулрах нь бидэнд бараг ашигтай ч юм шиг ойлгогдоод байна. Иймд оролцогчид ТС-ийн талаар хэлэлцэлгүй орхиж, зөвхөн НЭЗХДШ-д анхаарлаа хандуулж саналаа өгөх хүсэлтээ илэрхийлэв. Түүнчлэн ДБ заримдаа хэд хэдэн жижиг улс орнуудыг хамарсан нэг НЭЗХДШ хийдэг учраас Монгол улсад бие даасан НЭЗХДШ хийж байгаад нь оролцогчид талархалаа илэрхийлэв. • Дэлхийн банк нь НҮБ-ын нэг хэсэг учраас ДБ-ны зорилго, стратеги Тогтвортой Хөгжлийн Зорилтуудтай нийцэж байх ёстой. Гэвч оношилгоо, дүн шинжилгээний талаар мэдэхгүйгээр стратегийн талаар ярих боломжгүй. • НЭЗХДШ-г боловсруулах үйл явц оролцогч талуудаас санал авах зөвлөлдөөнийг олон үе шаттай зохион байгуулах ёстой. НЭЗХДШ-нд зөвлөлдөх уулзалтаар санал авахаас гадна нийгмийн аудит, иргэдийн онооны карт ашиглах, мониторинг хийх гэх мэт бусад арга хэрэгслийг ашиглан санал авч болдог. Монгол Улсад тулгамдаж буй өнөөгийн хүндрэл бэрхшээл, хүнд цаг үеийг харгалзан НЭЗХДШ-г боловсруулахдаа хөндлөнгийн үнэлгээний аргачлалыг ашиглахыг тусгайлан санал болгож байна. • Мөн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулахдаа тухайн баримт бичгүүдийн төсөлтэй танилцах боломжийг бүрдүүлж, оролцогчдод тарааж танилцуулсны дараа хийх нь зүйтэй. Энэ зөвлөлдөх уулзалтын хувьд бидэнд үзэж танилцах баримт бичиг алга; танилцах боломжтой цорын ганц баримт бичиг нь өмнөх ТС-ийн Гүйцэтгэл, Сургамжийн Тойм гэсэн материал байгаа боловч зөвлөлдөх уулзалтанд бэлтгэх суурь материал болгож оролцогчдод тараагаагүй байна. Зарим оролцогчид улс орны нөхцөл байдлыг оношилж дүн шинжилгээ хийж чадах шинжээчид ДБ-д байхад яагаад бусад оролцогч талуудаас саналыг нь асууж байгаа талаар өөр ойлголт, хүлээлттэй байв. Саяхан Монгол улсын Ерөнхийлөгч 20 гаруй жилийн хугацаанд Монгол улсад үзүүлсэн дэмжлэг туслалцааны үр дүн юу байсан талаар ДБ-наас асуусан байдаг. Иймд бодит нөхцөл байдлыг үнэлэхэд туслахын тулд ирээдүйд хөгжүүлэх чиглэлд анхаарлаа сарниулалгүйгээр өнөөгийн нөхцөл байдлын оношилгоо, дүн шинжилгээнд гол анхаарлаа хандуулах хэрэгтэй

байна. Цахим хуудсанд байршуулсан өмнөх зөвлөлдөх уулзалтуудын тэмдэглэлээс харахад ирээдүйд хөгжүүлэх шаардлагатай чиглэлүүд гэсэн асуудалд төвлөрсөн, хувийн хэвшлийн зүгээс уул уурхайг цаашид хөгжүүлэх салбар гэж тодорхойлсон мэт харагдаж байна.

- Оношилгоо, дүн шинжилгээний хэлэлцүүлэгт ашиглаж болох статистик тоо баримт бидэнд өнөөдөр алга байна. Мэдээлэл, нотолгоо байхгүй тохиолдолд хэлэлцүүлэг үр дүнгээ өгөхгүй байж болох талтай.
- Зөвлөлдөх гэж буй тухайн баримт бичгийн төсөл бэлэн болоогүй ч оролцогчдыг саналаа хэлэхийг хүсч байна. Иймээс оношилгоо, дүн шинжилгээг оролцооны аргаар боловсруулах гэж байгаа юм байна хэмээн ойлгож оролцогчдын зүгээс өнөөдөр ямар ч өгөгдөл мэдээлэлгүйгээр анхан шатны оношилгоо хийх гэж хичээхийг санал болгож байна. Өнөөдрийн зөвлөлдөх уулзалтын бүтээгдэхүүнийг дүн шинжилгээний дараагийн үе шатанд ашиглаж, дараа нь стратегийг боловсруулахад тусгаж болно. Бүлгийн хэлэлцүүлгийг зохион байгуулахдаа оролцогчдыг өөрсдийнх нь мэргэшсэн салбараар хувааж хэлэлцүүлэх нь зохистой.
- Зөвлөлдөх уулзалтын тэмдэглэлд хоёр чухал тусгай саналыг тусгахыг хүсч байна: (i) НЭЗХДШ болон ТС-ийг тусад нь боловсруулах. Эдгээр баримт бичгийг боловсруулахдаа бие даасан/хөндлөнгийн оношилгооны аргыг хэрэглэх. Энэхүү анхны уулзалтын дараа фокус бүлгийн ярилцлага зохион байгуулах, дараа нь бие даасан/хөндлөнгийн оношлогоо хийх хэрэгтэй; (ii) тус уулзалт болон өмнөх зөвлөлдөх уулзалтуудын үеэр илэрхийлсэн санал, зөвлөмжийг ТС-г оруулах санал гэж тооцохгүй байх.

Дээрх сэдэв болон НЭЗХДШ-ий үйл явцын талаар оролцогчдын дэвшүүлсэн бусад санал зөвлөмж:

- НЭЗХДШ нь малчдын хувьд нэн тулгамдсан асуудал болсон байгаль орчны асуудал, бэлчээрийн нөхцөл байдлыг тусгах ёстой.
- НЭЗХДШ-г боловсруулах үйл явцад “Хянагч”-ийн үүрэг гүйцэтгэх ИНБ-уудын төлөөллөөс бүрдсэн сайн дурын бүлэг байгуулахыг санал болгосон.
- 1990-ээд оны эхээр ДБ болон бусад хандивлагчдын тусламжтайгаар хөгжлийн загвараа тодорхойлоход туслах улс орны алсын хараа, хэтийн төлвөө тодорхойлох арга хэмжээг зохион байгуулж байсан. Бид одоо "байсан байрандаа" эргээд очсон байна. Иймд улсын орны алсын хараа, хэтийн төлвийг тодорхойлох арга хэмжээг дахин хийх шаардлагатай болсон байна. Үүнд НЭЗХДШ туслах нь зүйтэй.
- НЭЗХДШ-нд ТХХТ-ийг анхааралтай оношилж дүгнэх ёстой. Учир нь ТХХТ-ийг авилгын үндсэн шалтгаан гэж үздэг.
- Монгол улс “дефолт” буюу өрийн гэрээний дагуу үүргээ биелүүлэхгүй болох нөхцөл байдал үүсээд байна. Төр нь хувийн хэвшлийн гадаад өрийг хянаж чадахгүй байгаа учраас 1997 оны Азийн эдийн засгийн хямралаас сургамж авах хэрэгтэй. ДБ энэ талаар юу гэж бодож байна вэ?
- Эрх мэдэлд хэт төвлөрсөн, орон нутаг огт эрх мэдэлгүй байдал үүссэн учраас Монгол улсын ардчиллыг ДБ 2014 онд “гаж ардчилал” гэж нэрлэж байсан. Орон нутгийн төсвийн захиран зарцуулах эрх мэдлийг дэмжих чиглэлээр өөрчлөлт хийгдсэн. Энэ өөрчлөлтийн нөлөөг ДБ одоо хэрхэн үзэж байна вэ?
- Засаглал ДБ-ны хөтөлбөрийн томоохон хэсгийг эзэлдэг. Энэ чиглэлээр үзүүлсэн дэмжлэг тусалцаагаа ДБ хэрхэн үнэлж дүгнэж байна вэ?